

ТАНИЛЦУУЛГА

ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дэх заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах журам”-ын төслийг шинээр боловсруулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, болон Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичигт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олон улс, бүс нутгийн жишгээр бүрдүүлэн бий болгож, хөгжүүлэх замаар Органик хүнсний үйлдвэрлэл нь хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг бий болгох, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах экосистейн тэнцвэрт байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, зах зээлийг аюулгүй, чанартай хүнсний болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтээр хангах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх; хүний эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хамгаалах, улс орны эдийн засгийн өсөлтийг хурдасгахад энэхүү шинээр боловсруулж байгаа баримт бичиг чухал ач холбогдолтой.

Улсын Их Хурал 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Органик хүнсний тухай” хуулийг хэлэлцэн баталсан. 2017 оны 01 сараас хэрэгжиж эхэлсэн энэхүү хуулийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газар нь СХЗГ-ын даргын 2017 оны 03 сарын 03-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Органик хуулийг дагаж гарах журам, стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хэсгийн хүрээнд “Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах” журмын төслийг боловсруулсан болно.

----- о О о -----

Органик хүнснийг баталгаажуулах журам

1 Нийтлэг үндэслэл

Энэхүү баримт бичиг нь органик хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулах ерөнхий журмыг тогтоох бөгөөд сайн дурын, хөндлөнгийн баталгаажуулалтад хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү журмыг дараах эрхзүйн баримт бичиг, стандартуудад нийцүүлэн боловсруулсан. Үүнд:

- Органик хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйл
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- ОХААХОУХолбоо-ны суурь стандартын шаардлага \2015\
- MNS ISO\IEC 17067:2014 Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар
- MNS ISO\IEC 17065:2013 Тохирлын үнэлгээ- Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага
- Монгол улсад бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах журам
- MNS CAC 32:2017 Органик хүнснийг боловсруулах, үйдвэрлэх, шошголох, худалдаанд баримтлах арга зүйн удирдамж

3 Баталгаажуулах үйл явц

Органик хүнсний баталгаажуулалтад Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсад хэрэглэхийг зөвшөөрсөн олон улс, бүс нутаг, гадаад орны стандарт, журмыг үндэслэнэ. Органик хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүн, үйл явцыг баталгаажуулахдаа 1-р хавсралтад заасан үйл явцын дагуу дараах үе шатуудыг баримтлана. Үүнд:

3.1 Баталгаажуулалтад хамрагдах хүсэлт гаргах;

3.2 Баталгаажуулалтын байгууллага \ББ\ хүсэлт, баримт бичгийг хянан дүн шинжилгээ хийх

3.3 Органик үйлдвэрлэлд урьдчилсан аудит хийж, дүгнэлт гаргах

3.4 Баталгаажуулах тухай гэрээ байгуулах

- 3.5** Ажлын хэсэг тохирлын үнэлгээ явуулах
- 3.6** Органик ХАА-н үйлдвэрлэлийн шилжилтийн үеийн явцын хяналт хийх, тогтоох
- 3.7** Шилжилтийн үе дууссаныг баталгаажуулах үнэлгээ
- 3.8** Бүтээгдэхүүнээс дээж авах, шинжилгээнд хамруулах;
- 3.9** Гарсан үр дүнд дүн шинжилгээ хийх, органик хүнсний тохирлын гэрчилгээ (цаашид гэрчилгээ гэх) олгох /татгалзах тухай шийдвэр гаргах, гэрчилгээ олгох, гэрээ байгуулах
- 3.10** Баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйл явцад магадлах хяналт явуулах.

4 Баталгаажуулалтад хамрагдах хүсэлт гаргах

4.1 Байгууллага, иргэн нь 3-7-р хавсралтад дурьдсан (газар тариалан, мал аж ахуй, шувууны аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, загасны аж ахуй, боловсруулсан органик бүтээгдэхүүн, зэрлэг ургамал, мөөг, зөгийн аж ахуйн) зохионо органик үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллүүдийг агуулсан мэдэгдлийг бөглөн баталгаажуулалтын байгууллагад албан хүсэлтийн хамт хүргүүлнэ.

4.2 Хүсэлт гаргагч нь тухайн бүтээгдэхүүн, үйл явцыг баталгаажуулахад шаардлагатай зарим техникийн баримт бичгүүдийг өргөдөлд хавсаргасан байна.

Үүнд:

- түүхий эд, бүтээгдэхүүн, үйл явцын органик шинж чанарт тохирсон тухай нотолгоо \хөрс, бордоо, усалгаа, ургамал хамгааллын болон өсөлтийг дэмжих бодис, менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн гэх мэт\
- бүтээгдэхүүний гарал үүсэл, баталгаажуулсан байдал \ХОБ-ын гэрчилгээ гэх мэт\
- Органик бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүгнэлт
- Аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар

5 Баримт бичигт дүн шинжилгээ хийх

5.1 Баталгаажуулалтын байгууллага нь хүсэлтэд хавсаргасан органик үйлдвэрлэлийн тогтолцооны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, шаардлагатай техникийн баримт бичгүүд /ХОБ-ын гэрчилгээ, сорилтын дүн гэх мэт/ зэргийг үндэслэн үйлдвэрлэлийн технологийн болон удирдлагын тогтолцооны баримт бичигт MNS ISO\IEC 17065:2013 стандартын дагуу дүн шинжилгээ хийн урьдчилсан үнэлгээ болон шилжилтийн үеийг тогтоох эсэхийг шийднэ.

5.2 Баталгаажуулалтын байгууллага нь хэрэв шаардлагатай бол дүн шинжилгээний нэмэлт мэдээлэлд урьд нь хамрагдаж байсан хяналт шалгалтын дүн, органик үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, үйл явцын тодорхойлолт, шилжилтийн төлөвлөгөө, бүтээгдэхүүний тодорхойлолт, хэрэглэсэн орцын талаархи мэдээллийг шаардаж болно.

5.3 ББ нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногын дотор хүсэлт гаргагчид баталгаажуулалтыг хойшлуулсан, хүчингүй болгосон, түр хугацаагаар \6 сар\ түтгэлзүүлсэн бол үндэслэл шаардлагыг тодорхой тайлбарласан шийдвэрийн хамт мэдэгдэнэ.

6 Органик үйлдвэрлэлд урьдчилсан үнэлгээ хийж, дүгнэлт гаргах

6.1 ББ-ийн урьдчилсан үнэлгээ нь баталгаажуулалтын шийдвэрт үл нөлөөлөх органик үйлдвэрлэл, боловсруулалт явагдаж буй газар дээр нь үнэлгээ хийх зорилго бүхий хяналт юм.

6.2 Урьдчилсан үнэлгээг баримт бичигт дүн шинжилгээг хийсний дараа ажлын 10 хоногт багтаан газар дээр нь үйлдвэрлэл, үйл явц дээр явуулна.

6.3 ББ-ын томилогдсон аудитын баг дараах үйл явц дээр түүвэр байдлаар урьдчилсан үнэлгээ хийнэ. Үүнд:

- a) Органик үйлдвэрлэлийн байршил, хамрах хүрээ
- b) органик үйлдвэрлэлийн үйл явцын хэрэгжилт,
- c) органик үйлдвэрлэлийн эрсдлийн үнэлгээ
- d) үйлдвэрлэлийн талаархи асуулга, тандалт судалгаа,
- e) ХАА-н зохистой дадал нэвтрүүлсэн байдал,
- f) Органик орцыг тооцсон байдал
- g) ул мөрийг мөшгөх тогтолцоо нэвтрүүлсэн байдал,
- h) дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлсэн байдал

зэрэгт үнэлгээ хийж, органик үйлдвэрлэлд шилжих боломжтой эсэх талаар дүгнэлт гаргана.

6.4 Дүгнэлтийг гаргахад холбогдох олон улс бүс нутгийн стандарт, журмыг бүрэн хэрэгжүүлсэн байдлын үнэлгээг голчлон харгалзаж үзнэ.

7 Органик хүнсний үйлдвэрлэлийг баталгаажуулах тухай гэрээ байгуулах

7.1 Органик үйлдвэрлэл, боловсруулалтын шилжилтийн үе (органик зохион байгуулалтад шилжих эхэн үеэс үйлдвэрлэлийг органик хэмээн баталгаажуулах

үеийн хоорондох хугацаа) эхэлж, цаашид баталгаажуулах үйл явцад хамрагдах талаар ББ болон хүсэлт гаргагч үйлдвэрлэл эрхлэгчийн хооронд гэрээ байгуулна.

7.2 Энэхүү гэрээ нь шилжилтийн үеийн турш органик хүнсний үйлдвэрлэл, боловсруулалтыг тавигдсан шаардлагад нийцүүлэн технологи ажиллагааны дагуу эрхлэн явуулах, зохистой дадлыг хангах, бүртгэл баримтжуулалтыг хөтлөх, хоёр талын хүлээх эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон баримт бичиг болно.

4.3 Баталгаажуулах тухай гэрээнд 2-р хавсралтад заасны дагуу шилжилтийн үеийн хугацааг тогтоон, энэхүү хугацаанд 2 талын хяналтад хамрагдах хуваарийг гаргасан байна.

8 Органик хүнсний үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ явуулах

8.1 Органик ХАА-н үйлдвэрлэлийн шилжилтийн үеийн явцын хяналт явуулах

8.1.1 Шилжилтийн үед гэрээнд заасны дагуу органик үйлдвэрлэл, боловсруулалтыг эрхлэн явуулж байгаа байдалд эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас явцын хяналт, үнэлгээг гэрээнд заасан хуваарийн дагуу хийнэ.

8.1.2 Явцын хяналтаар гэрээнд заасан нөхцлүүдийг үйлдвэрлэл эрхлэгч бүрэн хэмжээнд хэрэгжүүлж чадаагүй нь тогтоогдвол шилжилтийн үеийг цуцлана. Харин органик үйлдвэрлэл, боловсруулалтыг гэрээнд заасны дагуу эрхлэн явуулж, түүхий эд, бүтээгдэхүүний органик байх нөхцлүүдийг ханган ажиллаж байвал баталгаажуулалтын байгууллагаас органик баталгаажуулалтыг хийх боломж бүрдсэн гэж үзнэ.

8.1.3 Баталгаажуулалтын шинжээч нь явцын хяналтын үр дүнгийн талаар батлагдсан маягтын дагуу тэмдэглэл хөтөлж, баримтжуулна.

8.2 Шилжилтийн үе дууссаныг баталгаажуулах үнэлгээ

8.2.1 Баталгаажуулалтын байгууллага нь гэрээнд заасан шилжилтийн үе дуусахад органик үйлдвэрлэл, боловсруулалтын үйл явц, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнд баталгаажуулах үнэлгээг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж, удирдамж буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллана. Удирдамжид гэрээний шаардлагуудыг багтаасан байвал зохино.

8.2.2 Ажлын хэсэг үйлдвэрлэл, үйл явц дээр очиж үнэлгээ хийхдээ дараах зарчмуудыг баримтлана. Үүнд:

- Олон улс, бүс нутгийн стандарт, журамд нийцэж буй эсэх

- Үнэлгээний үед ойлгомжтой, үл ялгаварлах ба бодитой олон улсын жишигт нийцсэн байх
- Ашиг сонирхлын зөрчилгүй байх, шударга, нээлттэй байх,

8.2.3 Органик хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулах үйл явцад дараах үнэлгээний болон сорилтын аргыг ашиглана. Үүнд:

- түүхий эд, бүтээгдэхүүн, үйл явцын органик шинж чанарт тохирсон, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлсэн байдал \хөрс, бордоо, усалгаа, ургамал хамгааллын болон өсөлтийг дэмжих бодис гэх мэтхөдөө аж ахуй болн эрүүл ахуйн зохистой дадал\
- бүтээгдэхүүний ангилал, гарал үүсэл
- Органик хүнсний үйлдвэрлэлийн тогтолцооны хэрэгжилт, баримтжуулалт, бүртгэлийн үйл ажиллагаа
- тухайн бүтээгдэхүүн, түүхий эд, үйл явц нь органик хүнсэнд тавигдах шаардлагыг бүрэн хангасныг үнэн зөв нотлох журам, стандарт, жор тооцолт;
- Органик бүтээгдэхүүний талаархи итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүгнэлт үйл явц болон бүтээгдэхүүнтэй холбоотой тандалт судалгаа явуулах

8.2.4 Үнэлгээний явцад үе шат бүрийг дараах байдлаар баримтжуулахдаа батлагдсан журам, аргачлалыг үндэслэл болгох шаардлагатай. Үүнд:

- a) үйлдвэрийн байр агуулах, тоног төхөөрөмж, талбай, газар ба хадгалалтын хэсгийг газар дээр нь очиж үзэх замаар үйлдвэрлэл, боловсруулалтын тогтолцоонд үнэлгээ өгсөн байдал;
- b) органик хүнсний үйлдвэрлэгчээс ББ-д асуумжийн дагуу бөглөж ирүүлсэн хамгийн сүүлийн мэдээллийг магадлах;
- c) эрсдэлтэй хэсгүүдийг олж тогтоох, тодорхойлох;
- d) тайлан болон бүртгэлд хянан магадлагаа явуулах;
- e) фермерийн аж ахуйн үйлдвэрлэл/худалдааны үйл ажиллагааны зохицуулалт;
- f) орц/гарцыг харьцуулах, боловсруулах болон бүтээгдэхүүнтэй харьцах ажиллагаанд гарал үүслийн хөндлөнгийн хяналт явуулсан эсэх;
- g) газар дээр нь хариуцаж буй этгээдээс ярилцлага авсан байдал;
- h) гэрээний шаардлагаар тогтоосон нөхцөл байдал хангагдсан тухай нотолгоо, үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд эерэг үр дүнд хүрсэн талаарх нотолгоо;
- i) Түүхий эд, бүтээгдэхүүний дээжийг холбогдох журмын дагуу сорилтонд хамруулсан байдал;

ТАЙЛБАР: орц/гарцын харьцуулалт гэдэг нь нийт бүрэлдэхүүн хэсгийг органик бүтээгдэхүүний гарцтай харьцуулах эсвэл худалдааны үйл ажилагааны хувьд түгээлтийн тоо хэмжээг худалдан авалтын тоо хэмжээтэй харьцуулсан хөндлөнгийн үнэлгээ

8.2.5 Томилогдсон ажлын хэсэг дараах мэдээллийг агуулсан баримт бичгийг үндэслэн шинжээчийн дүгнэлтэд тусгана. Үүнд:

- a) ажлын хэсгийн үнэлгээний тайлан,
- b) үйлдвэрлэлийн үйл явц нь тогтоосон шаардлагад нийцсэн байдал,
- c) органик тогтолцооны хэрэгжилт,
- d) органик орцыг тооцож баталгаажуулсан байдал
- e) сорилтын үр дүн,
- f) баримт бичигт хийсэн дүн шинжилгээ

8.2.6 Органик үйлдвэрлэлийн шилжилтийн үе болон баталгаажуулалтын үйл явцын холбогдон гарах бүх зардлыг үйлдвэрлэгч тал бүрэн хариуцна. ХУУЛИАС ХАРАХ

9 Бүтээгдэхүүний дээж авах, шинжилгээнд хамруулах

9.1 Баталгаажуулалтын байгууллага нь органик үйлдвэрлэлийн үйл явц, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнд генийн өөрчлөлтийн талаархи болон холбогдох стандарт, журмаар хориглосон бодисын хэрэглээ илэрч болзошгүй гэж үзвэл шинжилгээнд зориулан дээж авах шаардлагатай.

9.2 Бүтээгдэхүүний орцын талаар эсхүл хөрсөнд агуулагдах бохирдол, үлдэгдэл гэх мэт органик бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үе шатанд хамаарах үзүүлэлт нь стандартын шаардлагад нийцэж буйг шинжилгээнд тулгуурлан тогтооно.

9.3 Бүтээц, бүрэлдэхүүн, үйлдвэрлэлийн технологийн хувьд хэрэглэгчид нийлүүлж буй бүтээгдэхүүнтэй ижил загварын дээжинд сорилт, шинжилгээг явуулна.

9.4 Дээж авахдаа тогтоосон олон улс бүс нутгийн стандарт, журмыг баримтлана.

9.5 Дээжийг томилогдсон баталгаажуулалтын шинжээч авна.

9.6 Баталгаажуулалтын сорилтыг итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид гүйцэтгэнэ. Шинжилгээний зардлыг үйлдвэрлэгч тал хариуцна.

9.7 Сорилтын дүнгийн хуудсыг тохирлын үнэлгээний материалд хавсаргана

10 Гарсан үр дүнд дүн шинжилгээ хийх, тохирлын гэрчилгээ олгох /татгалзах тухай шийдвэр гаргах

10.1 Аудитын багийн дүгнэлтийг үндэслэн ББ-ын дэргэдэх орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөл органик хүнсний тохирлын гэрчилгээ олгох эсэх шийдвэрийг гаргана.

10.2 Баталгаажуулалтын зөвлөлд хэлэлцүүлэх органик хүнсний үйлдвэрлэлийн үйл явц, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх үнэлгээний тайланд дараах асуудлуудыг зайлшгүй тусгана. Үүнд:

- a) органик хүнсний үйлдвэрлэлийн эрсдэлийн үнэлгээ
- b) шилжилтийн хугацаан дахь хяналтын үйл явц, тайлан
- c) хяналт эхлэсэн он сар өдөр, үргэлжилсэн хугацаа;
- d) үйлдвэрлэгчийн мэдээлэл
- e) органик үйлдвэрлэлийн тандалт судалгааны тайлан;
- f) газар дээр нь үнэлгээ хийгдсэн байдал, талбай, байршил;
- g) хөндлөнгийн хяналт хийгдсэн баримтжуулалтын төрлүүд (орц/гарц, га-аас авах ургацын хэмжээ/борлуулалт, гарал үүсэл, гэх мэт.)
- h) стандартад нийцэж буй эсэх талаарх баталгаажуулалтын ажилтны дүгнэлт гэх мэт тусгагдсан байна.

10.3 Баталгаажуулалтанд хамрагдаж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь шаардлагад нийцэж буйг батлах зорилгоор Баталгаажуулалтын зөвлөлөөс гаргасан органик хүнсний тохирлын гэрчилгээ олгох шийдвэрийг Стандартчиллын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын дарга баталгаажуулж, гэрчилгээ олгоно.

10.4 Бүтээгдэхүүний сорилт сөрөг гарсан, үйл явцын үнэлгээний үр дүн хангалтгүй тохиолдолд Баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээ олгохоос татгалзсан тухай шийдвэрийг шалтгааны хамт хүсэлт гаргагч үйлдвэрлэгчид албан тоотоор хүргүүлнэ.

10.5 Гэрчилгээний хүчинтэй хугацааг тухайн бүтээгдэхүүн, үйл явцын шилжилтийн үеийн хугацаа, органик үйлдвэрлэлийн үйл явцын хэрэгжилт /баталгаажуулалтын схемийн дагуу/ зэргийг харгалзан Баталгаажуулалтын байгууллага 2 жил хүртэл хугацаагаар тогтооно

10.6 Тохирлын гэрчилгээтэй органик хүнсний үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний органик шинж чанар, органик шаардлагын нийцлийг гэрчилгээний турш хадгалах зорилгоор гэрчилгээ эзэмшигчтэй “Органик хүнсний бүтээгдэхүүн, үйл явцын тохирлын гэрчилгээ эзэмших гэрээ” байгуулна.

10.7 Гэрээнд гэрчилгээ эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлага, баталгаажуулалтын байгууллагаас холбогдох мэдээллээр хангах, магадлах хяналт хийх хуваарь зэргийг тусгагдсан байна.

10.8 Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн мэдээллийг Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногийн дотор хүргүүлж, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэн органик болохыг илэрхийлсэн тэмдэг олгох эрхийг нээж өгнө.

10.9 Мэдээллийн санд бүртгүүлэхдээ дараах баримт бичгүүдийг хавсаргаж өгнө.

Үүнд:

- a) үйлдвэр эрхлэгчийн нэр хаяг
- b) Органик хүнсний бүтээгдэхүүн, үйл явцын тохирлын гэрчилгээ, гэрээний хуулбар
- c) Шилжилтийн үеийн үнэлгээ
- d) Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтийн дүн.....

10.10 Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээ нь дараах мэдээллийг зайлшгүй агуулсан байна. Үүнд:

- a) органик үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийн нэр, хаяг
- b) баталгаажуулсан этгээдийн нэр, хаяг
- c) аж ахуй эрхлэгчийн хамруулж буй баталгаажуулалтын хөтөлбөрийн нэр
- е) зохих стандарт, техникийн зохицуулалтыг иш татсан, баталгаажуулалтын хамрах хүрээ, бүтээгдэхүүн болон бүтээгдэхүүний ангилал
- e) олгосон он сар өдөр
- f) хүчинтэй хугацаа
- g) баталгаажуулалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга

11 Баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйл явцад магадлах хяналт явуулах

11.1 Баталгаажуулалтын байгууллага нь органик хүнсний баталгаажсан үйлдвэрлэгчийг жилд нэг удаагийн хугацааны давтамжтайгаар магадлах хяналтанд хамруулна. Магадлах хяналтын цаг хугацааг тодорхойгүй байдлаар тухай бүр товлож болно.

11.2 Магадлах хяналтын давтамж болон хамрах хүрээг дараах зүйлсийг харгалзан тогтооно. Үүнд:

- a) Бүтээгдэхүүн, түүхий эд болон үйлдвэрлэлийн органик мөн чанарт учруулах аюулын зэргийг тооцоолсон эрсдэлийн үнэлгээ,
- b) үйлдвэрлэлийн тогтвортой байдал,
- c) үйлдвэрлэлийн хэмжээ,
- d) органик үйлдвэрлэлийн үе шат, хамрах хүрээ
- e) магадлах хяналтын өртөг

11.3 Магадлах хяналтыг эрх бүхий байгууллагаас баталсан баталгаажуулалтын сонгосон схемийн шаардлагад нийцүүлэн явуулна.

11.4 Төлөвлөгөөт бус магадлан хяналтыг хэрэглэгч, худалдааны сүлжээ, түүнчлэн хяналтын байгууллагуудаас органик бүтээгдэхүүнтэй холбоотой гаргасан гомдлын тухай мэдээллийн дагуу явуулна.

11.5 Магадлах хяналтын үр дүнг баримтжуулж, баримт бичгийн эх хувийг баталгаажуулалтын байгууллагад хадгална. Хувийг өргөдөл гаргагчид болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хяналтын байгууллагад мэдээллийг тус тус хүргүүлнэ.

11.6 Магадлах хяналтын үр дүн болон дараах хүчин зүйлсээс шалтгаалан баталгаажуулалтын шаардлагад үл тохирох байдалд хүргэх нөхцөл бүрдсэн гэж үзвэл гэрчилгээг түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгож болно. Үүнд:

- a) органик үйлдвэрлэлийн шаардлагыг хангахгүй байх;
- b) бүтээгдэхүүний буюу сорилтын аргын норматив баримт бичигт өөрчлөлт орох;
- c) бүтээгдэхүүний бүтээц, орцод өөрчлөлт орох;
- d) үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн горимд өөрчлөлт орох; гэх мэт

11.7 Эдгээр үл тохирол илэрсэн тохиолдолд Баталгаажуулалтын байгууллагаас дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) энэхүү журамд 11.6-д заасны дагуу гэрчилгээг түдгэлзүүлэх;
- b) эрх бүхий сонирхогч талуудад мэдээлэх;
- c) залруулах арга хэмжээг биелүүлэх хугацааг тогтоох;
- d) залруулах арга хэмжээг биелүүлж буй байдалд хяналт тавих.

11.8 Үл тохирол илэрсэн тохиолдолд үйлдвэрлэгч талаас дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a. илэрсэн үл тохирлын хамрах хүрээ /зөрчилтэй бүтээгдэхүүний тоо хэмжээ, загвар, бүтээгдэхүүний гарал үүсэл, найрлага гэх мэт 11.6-д заасан/-г тодорхойлох;
- b. эрх бүхий сонирхогч байгууллагуудад уг бүтээгдэхүүний үл нийцлийн талаар мэдэгдэх.

11.9 Гэрчилгээ эзэмшигч буюу үйлдвэрлэгч нь ББ-тай зөвшилцөж, тогтоосон залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар илэрсэн үл тохирлыг арилгаж, шаардлагад тохирсныг баталж чадах хүртэл ББ тохирлын гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэрийг гаргана. Үл тохирлыг залруулж чадаагүй тохиолдолд гэрчилгээг хүчингүй болгоно.

11.10 Гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсвэл хүчингүй болгосон тухай мэдээллийг ББ нь Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхий

хяналтын байгууллага, худалдааны сүлжээ болон бусад сонирхогч талуудад хүргэнэ.

11.11 Илэрсэн үл тохирлыг бүрэн залруулагдсаны дараа ББ нь залруулах арга хэмжээний өмнө ба дараах үеийн бүтээгдэхүүнийг ялгах, шинэ тэмдэглэгээг үйлдвэрлэгчээр тавиулах арга хэмжээ авна.


10 Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын схем


10.1 Баталгаажуулалтын схемийг бий болгох зааврыг MNS ISO\IEC 17067:2014 “Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүнийг баталгаажуулалтын схемийн заавар” стандартын дагуу бий болгоно. Органик үйлдвэрлэлийн үйл явцын баталгаажуулалтыг MNS ISO\IEC 17067:2014 стандартын Схемийн төрөл 3 дагуу баталгаажуулалт хийгдэнэ.

10.2 Энэхүү схемийг органик үйлдвэрлэлийг анх удаа туршин нэвтрүүлж, баталгаажуулалт хийлгэж буй нөхцөлд хэрэглэхэд зохимжтой. Энэ схемийн магадлах хяналтын хэсэг нь бүтээгдэхүүний дээжийг тодорхой хугацааны давтамжтайгаар үйлдвэрлэлийн хэсгээс аваад тогтоосон шаардлагыг хангасан анхны үнэлгээний дагуу үйлдвэрлэгдсэн эсэхийг шалгах тодорхойлолтын үйл ажиллагаанд хамруулна. Энэ схемээр тохиролд нөлөөлөх түгээлтийн сүлжээний аливаа нөлөөллийг заахгүй. Хэрэв ноцтой үл тохирол илэрвэл зах зээл рүү түгээхээс өмнө шийдвэрлэнэ.

10.3 Органик үйлдвэрлэлийн давтан үнэлгээг MNS ISO\IEC 17067:2014 стандартын Схемийн төрөл 4 дагуу явуулна. Схемийн дагуу дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- a) бүтээгдэхүүний дээжийг тодорхой хугацааны давтамжтайгаар үйлдвэрлэлийн хэсгээс
- b) эсвэл зах зээл дээрээс
- c) эсвэл аль алианаас нь сонголт хийж аваад, тогтоосон шаардлагыг хангасан анхны үнэлгээний дагуу үйлдвэрлэгдсэн эсэхийг шалгах тодорхойлолтын үйл ажиллагаанд хамруулна. Магадлах хяналтад үйлдвэрлэлийн үйл явцын үнэлгээ багтана.
- d) Энэ схемээр тохиролд нөлөөлөх түгээлтийн сүлжээний нөлөөлөл болон ноцтой үл тохирлыг илрүүлэх, шийдвэрлэх зэрэг зах зээлд гаргахын өмнөх механизмын аль алиныг заана.





Алхам 1


Алхам 2

Хавсралт 2

Газар тариалан, үр тариалангийн органик үйлдвэрлэлийн шилжилт (36 сар)

Баталгаажуулалтын байгууллагыг сонгох

Зэрэгцээ



Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын асуумж

Хариуцсан хүн (Нэр, гарын үсэг)

Хүсэлт гаргасан он сар

YYYY MM DD

өдөр

(Газар тариалан)

ТАЙЛБАР: Асуулгад оролцож буй хуулийн этгээд тамга дараагүй бол хүчин төгөлдөр бус гэж тооцно.

Стандарт, хэмжил зүйн газрын төв байр

Энхтайваны өргөн чөлөө 46А Баянзүрх дүүрэг,

Улаанбаатар хот. 13343 Утас: 458349, 263860

Хэсэг 1 Үндсэн мэдээлэл

1 Үйлдвэрлэлийн нэгжийн нэр ба хаяг:

Үйлдвэрлэлийн үндсэн нэр, хаяг			
Үйлдвэрлэлийн хамрах хүрээ			
Үйлдвэрлэлийн дарга		Утас/Гар утас	

2. Үйлдвэрлэлийн байгууламж ба зохион байгуулалтын загвар

2.1 Байгууллагын загвар

- Корпораци/комдани Хамтын оролцоот
- Корпораци + Фермер+ хоршоо
- Бусад,

2.2 Үйлдвэрлэлийн нөхцөл

- Хээрийн Хүлэмжийн
- Хээрийн болон хүлэмжийн

3. Үйлдвэрлэлийн хэсгийн байгаль орчны байдал

Нийт талбай (m)	
Жилийн хур тунадасны хэмжээ (mm/year)	
Хяруу (days/year)	
Жилийн дундаж температур (°C)	

4. Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын түүх

<p>Органик бүтээгдэхүүн нь бусад баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулж байсан уу? Хэрэв тийм бол, баталгаажуулалт байгууллага болон гэрчилгээний хүчинтэй хугацааг заана уу.</p>	
<p>Органик үйлдвэрлэлд баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээ олгохыг татгалзсан эсвэл хүчингүй болгосон тохиолдол байна уу. Хэрэв тийм бол баталгаажуулалтын байгууллагын нэр хүчингүй болсон шалтгааныг заана уу.</p>	

Хэсэг 2 – Газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтолцоо

1. Шилжилтын хугацаа

1.1 Үйлдвэрлэлийг шинээр нөхөн сэргээлт хийсэн газар болон урт хугацааны атаршсан газар дээр барьсан уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгийг хавсаргах буюу атаршсан огноог тэмдэглэнэ үү.

1.2 Органик үйлдвэрлэлийн хэдэн оноос эхлүүлсэн бэ?

2. Орчны бүс

2.1 органик үйлдвэрлэлийн талбайн ойролцоо бохирдлын аливаа эх үүсвэр бий юу?

Хот суурин газар

Уурхай их

Замын хөдөлгөөний бүсд

Аж үйлдвэрийн бохирдлын эх үүсвэр

Хатуу хог хаягдал

Бусад

Хэрэв тийм бол органик үйлдвэрлийн бсд байх зай, талбайг заана уу _____m ;

Органик үйлдвэрлэлийн чиглэлд шууд холбоотой: Салхины эсрэг Салхины дагуу

2.2 Ойролцоо орших ердийн үйлдвэрлэл нь органик үйлдвэрлэлд ямар нэгэн эрсдэл учруулах уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол орчны бүс болон саад тотгорыг заана уу?:

Ой мод Зам Бургас Зэрлэг ургамал Хөдөө аж ахуйн эдэлбэр Гол, мөрөн

Өвс Бусад:

Өндөр болон орчны физикийн эрсдэл. _____m

3. Бусад хүчин зүйл

3.1 Санал болгож буй бүтээгдэхүүнтэй ижил төстэй үйлдвэрлэлийн орчинд баталгаажуулаагүй органик бус ургамал байгаа эсэх?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол ургамлын нэр, газар тариалангийн хэмжээг бичнэ үү?

3.2 Үйлдвэрлэлийн нэгж талбайд органик бус ижил ургамал байна уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол ижил ургамлын нэр, талбайн хэмжээг тодорхой бичнэ үү?

4. Үр болон ургамлын тархалтын материал

Органик үйлдвэрлэлд холбоотой үйлдвэрлэлийн нэгж хэрэглэж байгаа бол

No.	Нэр, сорт	Үрийн/суулгацны эх үүсвэр		Үрийн шинж чанар		Ашигласан хэмжээ (kg/mu)	Тарих \суулгах\ хугацаа	Генийн өөрчлөлттэй үр буюу пестицидтэй үлдэгдэлтэй үр?
		Хадгалалт	Худалдан авалт	Органик	Уламжлалт			
1		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
2		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
3		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
4		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			
5		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>			

6.3 Хэрэв бордооны хэрэглээнд ялзмаг байгаа бол түүхи эд, үйл явцын бүрэлдэхүүний эзлэх хувийг тодорхойлно уу (шаардлагатай тохиолдолд материалыг хавсаргах) :

7. Гурван жилийн өмнөх газрын үр шимтэй байдлыг тодорхойлох

Жил	Plot No.	Газар, талбай (Гкв)	Суулгацын нэр	Бордооны нэр	Түүхий эд материал найрлага	Бордооны эх үүсвэр	Хэрэглэх хэмжээ (ton)	Хэрэглэсэн хугацаа

8. Жилийн турш хийсэн хортон шавьжийн хяналт

8.1 Өвчнөөс урьдчилан сэргийлэх

8.1.1 Арга хэрэгсэл

- Өвчний тэсвэртэй сорт Ургуулсан суулгац Химийн бус үрийн эмчилгээ
 Цаг тухайд нь тариалах Газар хагалах ба solarizing Цэвэр талбар
 Газар тариаланг эргүүлэх Lying idle Өвчилсөн ургамал Eliminating
 Ургамлын нягтралын хяналт Нутагшуулсан суулгац
 Бусад, дурьдана уу.

8.1.2 Өвчинтэй тэмцэхэд хэрэглэсэн бодисын хяналт

- Үйлдвэрлэлийн нэгжид хэрэглэдэггүй холбоотой бус.

Plot No.	Суулгацын нэр	Талбай (mu)	Өвчний нэр	Бодисын нэр	Идэвхитэй нэгдэл	Хэрэглэх хэмжээ	Үр нөлөө үзүүлэх хугацаа

8.1.3 Хэрэв өвчлөлийн хяналтын бодисоор зэс хэрэглэж байгаа бол хэрэглэсэн хэмжээг тодорхойлно уу (зэсээр)

- >6kg Cu/ha/year ≤6kg Cu/ha/year

8.3 Хог ургамалтай тэмцэх хяналт

8.3.1 Зэрлэг ургамал, хог ургамлын гарах улирлыг хэлнэ үү

.....

8.3.2 Арга хэрэгслүүд

Тариалалтыг сайжруулах менежмент

Crop rotation

Цаг хугацаанд нь тариалах

Intertillage weeding

Хөрсийг утах

Manual weeding

Flame weeding

Уураар түүх

Weeder

Animal stocking

Mulching

Хатсан өвс ногоо

Irrigation weeding

Бусад, дурьдана уу:

9. Гурван жилийн хугацаан дахь хортон шавьжийн хяналт

Жил	Plot No.	Талбай (mu)	Хортон шавьжийн хяналт					Хог ургамлын менежмент	
			Ургац нэр	Хортон нэр	Бодис нэр	Хэрэглэх хэмжээ	Хэрэглээний хугацаа	Хог ургамлын нэр	Хяналтын аргууд

10. Тариалалтын тогтолцоо

10.1 Газар тариаланд сэлгэлт хийх, intercropping, арга хэрэглэж байсан уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол, газар тариалан сэлгэн нь ургамал indicate уу:

Нийт талбай (mu)									

Тайлбар

1. өөр өөр сорт, газар ургацыг тус тусад нь дугаарлана болон хашаанд дугаарласан болохгүй.

2 Тодорхой хугацаа нь өсөлт мөчлөгийн хангасан байх ёстой (жишээ нь: Мау XX-Есдүгээр XX)

12. Өмнөх гурван жилийн хугацаан дахь тарих хураах тоо хэмжээ

Жил	Plot No.	Талбай (mu)	Тарианы нэр	Ургацын цаг	Гарц (kg/mu)	Үйлдвэрлэл (ton)

13 Бохирдуулагчийн хяналт

13.1 Органик бүсийн дотор ердийн тариалангийн талбай нь услах сарнисан үү? Органик газар тариалангаас органик талбайд нэвтрэн орох, тархах уу?

Тийм Үгүй Холбоотой бус

13.2 Бордооны гадаад эх үүсвэрүүд нь хориотой бодисыг органик үйлдвэрт бохирдуулах шалтгаан болдог уу?

Тийм Үгүй Холбоотой бус

13.3 Органик үйлдвэрлэлд хэрэглэхээсээ өмнө уламжлалт фермийн системийг цэвэрлэж байна уу?

Тийм Үгүй Холбоотой бус

13.4 Хамгаалалтын хавтас, хуванцар кино, шавьжны тор хэрэглэдэг үү?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол материалыг заана уу:

Полиэтилен Полипропилен Полихлоринат Полихлоринжуулсан материал

Бусад

13.5 Хэрэглэсний дараа хамгаалалтын бүрхүүлийг арилгасан уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол зайлуулах арга:

Шатаах Төвлөрсөн эмчилгээ Бусад, бичнэ үү _____.

14 Ус, хөрсний хамгаалал ба биологийн төрөл зүйлийг хамгаалах

14.1 Хөрсний элэгдэл, цөлжилт, давсжилтаас сэргийлэхийн тулд авсан арга хэмжээ

- | | | |
|--|---|---|
| <input type="checkbox"/> Терезууд | <input type="checkbox"/> Тарваганы хагалгаа | <input type="checkbox"/> Strip-tillage |
| <input type="checkbox"/> Үржүүлэх, суулгах | <input type="checkbox"/> Хязгаарлагдмал газар тариалан / газар тариалангийн бус | <input type="checkbox"/> Усжуулалтын байнгын суваг |
| <input type="checkbox"/> Салхин сэнс байгууламж | <input type="checkbox"/> Firebreaks | <input type="checkbox"/> Ой |
| <input type="checkbox"/> Шүүгч | <input type="checkbox"/> Буудлын менежмент | <input type="checkbox"/> Зэрлэг амьтны амьдрах орчинг хамгаалах |
| <input type="checkbox"/> Өвлийн газар тариалангийн бүрхүүл | <input type="checkbox"/> Бусад, бичнэ үү | |

14.2 Байгалийн дайсан, тэдний амьдрах орчныг хамгаалах арга хэмжээ авдаг уу?

- Тийм Үгүй

14.3 Ургац хураалтын дараа ургацын үлдэгдэл хэрхэн цэвэрлэсэн бэ?

- Хөрсөөр булах Талбайгаас гаргах Шатаах Бусад, бичнэ үү _____ ;

Хэрэв шатаасан бол шалтгааныг тайлбарлана уу.

Хэсэг 3-Ургацийн боловсруулалт

Энэ хэсэг нь зөвхөн ургамлын ургац боловсруулалтанд хэрэглэнэ.

1. Сортлох, цэвэрлэх ба бусад ургац боловсруулалтын үйл ажиллагаа

1.1 Хураалтийн арга хэрэгсэл

Машинаар Гар аргаар

1.2 Хураалтийн дараах боловсруулалт

Боловсруулаагүй Цэвэрлэх Сортлох Threshing

Shelling Cutting Preservation Хатаах

Бусад, дурьдана уу

1.3 Органик болон органик бус хэрэглэх тоног төхөөрөмжийг ялгаатай хэрэглэдэг үү?

Тийм Үгүй

1.4 Тоног төхөөрөмжинд халдваргүйжилтийн бодис хэрэглэдэг үү?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол ариутгах болон цэвэрлэгээний бодисыг дурьдана уу:

2. Оролт ба гаралт

Эцсийн бүтээгдэхүүний нэр	Орсон материалын нэр	Орсон материалын нэр (ton)	Үйлдвэрлэлийн үр ашиг (%)	Бэлэн бүтээгдэхүүний гарц (ton)

3. Савлалт, Хадгалалт, Тээвэрлэлт

3.1 Савлалт

Бүтээгдэхүүнээ савласан уу?

Тийм Үгүй . Хэрэв тийм бол савлагааны материалыг дурьдана уу.

Сав баглаа боодлын материалд хортой бодис бий эсэх?

Тийм Үгүй . Хэрэв тийм бол бодисын нэрийг дурьдана уу:

Сав баглаа боодолд тусгаарлагч бий эсэх?

Тийм Үгүй . Хэрэв тийм бол тусгаарлагчийн нэр.

3.2 Хадгалалт

Холбоотой бус

Агуулахын нэр	Агуулахын шинж чанар		Багтаамж (ton)
	Өмчийн	Түрээсийн	

Хэсэг 4 Шошголотод болон худалдаа

1. Шошголот

Холбоотой бус

1.1 Баталгаажсан органик бүтээгдэхүүнийг борлуулахдаа бүтээгдэхүүнд шошго эсвэл код тавьдаг уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол, арга хэрэгслийг заана уу:

Органик шошгыг худалдан авдаг уу!

Өөрснөө хэвлэдэг үү?

2. Худалдаа

Холбоотой бус

Органик бүтээгдэхүүнийг борлуулахад мөшгөлтийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлсэн эсэх:

Органик бус бүтээгдэхүүнтэй цуг эсэх

Хориотой бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх

Худалаанд, хадгалах, агуулах, тээвэрлэх хэсэгт бүртгэлүүдийг бүртгэсэн эсэх

Бусад (дурьдана уу)

Хэсэг 5 Менежментийн тогтолцоо

1 .Баримт бичиг

1.1 Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичиг нь хамгийн сүүлийн үеийн хүчин төгөлдөр хувилбар мөн эсэх?

Тийм Үгүй

1.2 Хүчин төгөлдөр хувилбарыг хянасан эсэх?

Тийм Үгүй

1.3 Органик үйлдвэрлэлд мөрдөж буй бүртгэлүүд хүчин төгөлдөр баталгаажуулсан эсэх?

Тийм Үгүй

2. Тогтолцооны нөөц

Нэр	Албан тушаал	Органик бүтээгдэхүүнд мөрдөж буй үндэсний стандарт ижилтгэсэн байдал		Tenure
	Үйлдвэрлэлийн менежер	<input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Хэсэгчилсэн	<input type="checkbox"/> Их <input type="checkbox"/> Суурь	
	Дотоодын ЧМ	<input type="checkbox"/> Бага <input type="checkbox"/> Хэсэгчилсэн	<input type="checkbox"/> Их <input type="checkbox"/> Суурь	

Мэдэгдэл

Би үүгээр миний хувийн туршлага, мэдлэг, чадварыг хүрээнд нотлох, санал асуулгын заасан үйлдвэрлэл, боловсруулалт, удирдлагын талаарх мэдээлэл нь үнэн зөв гэж нотлож байна. Би үүгээр органик бүтээгдэхүүний стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор дээж авах, хяналт шалгалт, бүртгэл зэргийг шаардлагатай тохиолдолд газар дээр нь шалгахыг хүлээн зөвшөөрч байна.

Албан тушаалтны нэр (Гарын үсэг):

Баталгаажуулалтын шинжээч (Гарын үсэг):

Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын асуумж
(Мал аж ахуй болон шувууны аж ахуй)

Хүсэлт гаргачийн нэр (Компанийн нэр)

Хариуцсан хүн _____

Хүсэлт гаргасан он сар YYYY MM DD
өдөр _____

ТАЙЛБАР: Асуумжинд оролцож буй хуулийн этгээд тамга дараагүй бол хүчин төгөлдөр бус гэж тооцно.

Стандарт, хэмжил зүйн газрын төв байр
Энхтайваны өргөн чөлөө 46А Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот. 13343 Утас: 458349, 263860

I хэсэг Үндсэн мэдээлэл

1 Үйлдвэрлэлийн аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн нэгж

Үйлдвэрлэлийн нэр (үйлдвэрлэгч)			
Эзэмшил (үйлдвэрлэгч)	<input type="checkbox"/> Төрийн өмчит	<input type="checkbox"/> Хувийн	<input type="checkbox"/> Хувь хүн
	<input type="checkbox"/> Хамтарсан хувьцаат	<input type="checkbox"/> Бусад	
Хаяг / Шуудан			
Холбогдох хүн		Утас	

2. Органик үйлдвэрлэлийн зохион байгуулалтын загвар

2.1 Органик үйлдвэрлэлийн зохион байгуулалтын загвар

- корпораци Корпораци + Фермер
- Корпорац + хоршоод Хоршоод + фермер
- Холбоо Бусад

Хэрэв фермерүүд бодит үйлдвэрлэлд оролцсон бол фермерүүдийн тоог заана уу:

2.2 Баталгаажуулах үйлчлүүлэгч (өргөдөл гаргагч) болон үйлдвэрлэлийн нэгжийн хоорондын харилцаа:

- Өөрийн Аутсорсинг
- Бусад, бичнэ үү :

3. Үржлийн төрөл ба хугацаа

3.1 Тэжээлийн төрөл

- Байгалийн бэлчээр Тэжээвэр
- Тэжээвэр + Байгалийн бэлчээр

3.2 Үржлийн төрөл, тоо хэмжээ, хугацаа (бүтээгдэхүүн нь янз бүрийн үржлийн үетэй бол тусад нь бөглөнө үү)

No.	Нэр	Тоо хэмжээ	Үржлийн үе (өдөр)
1			
2			
3			
4			
5			

Үрийг нь тусад нь бөглөнө, үүнд худалдааны мал, үржлийн мал, малын тэжээлд хуваагдна.

4. Гэрчилгээний түүх

4.1 Өмнөх сертификатын хүсэлтийг татгалзсан уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол байгууллагын нэрийг бичнэ үү:

Шалтгаан:

4.2 Ямар нэгэн сертификатыг хүчингүй болгосон уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол байгууллагын нэрийг бичнэ үү

Шалтгаан:

4.3 Үйлдвэрлэлийн нэгжийг баталгаажуулалтын бусад байгууллагаас ямар нэг органик баталгаажуулалтыг өгдөг үү?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол байгууллагын нэрийг бичнэ үү

Жил: -----

4.4 Өмнөх баталгаажуулалтын үр дүн

Органикийн хувиргах баталгаажуулалт Органикийн баталгаажуулалт

Хамааралгүй

4.5 Өмнөх жилийн органик баталгаажуулалтын үл тохирлын зүйлүүд ба залруулгын байдал (олон зүйл байвал олон хүснэгтийг хавсаргана.)

Үл тохирлын зүйл	Баталгаажуулалт ба үр дүн

5. Экологийн орчин

Малын фермийн ойр орчимд 10 км-ийн зайд уурхайн олборлолт, химийн үйлдвэр, хог хаягдал зэрэг бохирдлын эх үүсвэр байгаа юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
МАА-н үйлдвэрлэл нь тодорхой хил хязгаартай юу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Фермерийн урсацын урсац нь аливаа аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дотоодын бохирдуулагчийг агуулсан уу?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
МАА-н аж ахуйд бохирдуулах бодисууд GB18596-ийн журмыг дагаж мөрддөг үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

6. Бусад мэдээлэл

6.1 Сүүлийн гурван жилд үйлдвэрлэлийн нэгж нь энэ жилтэй харьцуулахад үржлийн аргууд, өвчинтэй тэмцэх, малаа оруулах, тээвэрлэх, нядалгаа хийх ижил бүртгэлтэй юу? (Үйлдвэрлэлийн 4-өөс доош жил үйлдвэрлэсэн нэгжийг үйлдвэрлэсэн үеэс эхлэн дээр дурдсан мэдээллийг цуглуулна.)

Тийм Үгүй

Хэрэв тийм бол, энэ жилийн мэдээллийн дагуу "Үржлийн менежмент" II хэсгийг бөглөнө үү.

Хэрэв үгүй бол энэ жилийн мэдээллийн дагуу "Үржлийн менежмент" II хэсгийг бөглөж, тухайн жилийн үйлдвэрлэлийн байдлыг тайлбарласан мэдэгдэл хавсаргана уу.

6.2 Санал болгож буй бүтээгдэхүүнээс гадна үйлдвэрлэлийн нэг нэгжийн дотор гэрчилгээжүүлэх хүсэлт гаргаагүй бусад органик үйлдвэрлэсэн мал, шувууны бүтээгдэхүүн байна уу? Хэрэв тийм бол нэр, үйлдвэрлэлийн хэмжээ, эзлэхүүнийг заана уу.

Тийм Үгүй

Хэрэв тийм бол тайлбарлана уу:

6.3 Санал болгож буй бүтээгдэхүүнээс гадна үйлдвэрлэлийн нэг нэгжид организм үйлдвэрлээгүй бусад мал аж ахуй, шувууны аж ахуйн бүтээгдэхүүн байдаг уу? Хэрэв тийм бол органик бус бүтээгдэхүүний нэр, хэмжээ, хорио цээрийн менежментийн аргууд, үүнд байшин, зөөгч, дасгал, бэлчээр, тэжээл, мансууруулах бодисыг хянах.

Тийм Үгүй

Хэрэв тийм бол тайлбарлана уу

6.4 Үндэсний зайлшгүй вакцинаас гадна вакцин, мал эмнэлгийн эм, тэжээл зэрэг үйлдвэрлэлийн нэгжийн бусад орцууд нь генетикийн инженерчилсэн организмууд эсвэл генетикийн хувиргасан организм агуулдаг байсан уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол нэрээ бичнэ үү

6.5 Үйлдвэрлэлийн нэгжид ашиглагдаагүй цахилгааны хэрэглээ үү?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол түүнийг хаана хэрэглэж байгааг нь зааж өгнө үү.

Хэсэг II Үржлийн ба үйлдвэрлэл

Хэрэв өөр өөр үүлдрийн мал, шувууны гэрчилгээнд хэрэглэсэн бол эсвэл өөр өөр тариалалтын аргыг хэрэглэж байгаа бол тусдаа хүснэгтийг бөглөнө үү)

1. Feed Base

1.1 Зөвхөн байгалийн бэлчээрээр тэжээдэг мал, шувуу байна уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол Section 4. "Тэжээл" гэсэн хэсгийг орхигдуулж болно.

Бэлчээрийн талбай_____, бэлчээрийн даац_____, Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх_____ хугацаа

1.2 Тариалангийн газар, тариалангийн талбайд тэжээл өгдөг үү?

Тийм Үгүй Хэрэв тийм бол суурийн бүсийг зааж өгнө үү:

1.3 Органик фермээс нийлүүлдэг тэжээлийн бааз нь үйлдвэрлэлийн баазтай хамтран ажилладаг уу?

Тийм Үгүй Хэрэв тийм бол суурийн бүсийг зааж өгнө үү: m

1.4 Гаднаас тэжээлийг худалдан авах шаардлагатай (үүнд нэмэлт гэх мэт)?

Тийм Үгүй Хэрэв тийм бол тэжээлийн талаар бичнэ үү.

2. Зэрэгцээ үйлдвэрлэл

Нэг фермд орших органик болон органик бус аргаар хоёр төрлийн үүлдэр, ялгаагүйгээр үүлдрийг бий болгосон уу?

Тийм Үгүй

Хэрэв тийм бол менежментийн талаар тайлбарлана уу.

3. Мал, шувууны танилцуулга

Хамааралгүй (бүрэн өөрөө нөхөн үржихүй)

3.1 Органик мал, шувууны махыг нэвтрүүлсэн үү?

Тийм Үгүй

Ердийн мал, шувуу нэвтрүүлсэн бол дараах хүснэгтийг бөглөнө үү:

Янз бүрийн	Танилцуулгын тоо (толгой)	Нас / долоо хоног / хоногт (хэрэв танилцуулбал)

Оруулсан уламжлалт гэр бүлийн гишүүд үү?

Тийм Үгүй Хамааралгүй

If conventional dairy calves are introduced, have they been colostrum-fed and raised all by milk?

Тийм Үгүй Хамааралгүй

3.2 Ердийн үржлийн нөөцийг бий болгосон уу?

Тийм Үгүй Хамааралгүй

Хэрэв тийм бол органик гэрчилгээ авахын тулд нийт үнээний уламжлалт үржлийн эзлэх хувийг хэлнэ үү: _____%

Үнээний үрийн нөөцийг танилцуулахаас өмнөх дараахь нөхцөлийг хангасан уу?

Тийм Үгүй Хамааралгүй

Байгалийн гамшиг, хүний гараар хийсэн осол гэмтэл;

Фермерийн цар хүрээ ихээхэн өргөжсөн;

